



## Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: АШУҮИС, Сувилахуйн сургууль

Хөтөлбөрийн нэр: Эх барихуй бакалаврын хөтөлбөр

Индекс: 091302

Шинжээчийн баг:

Ахлагч: С.Эрдэнэтуул

Гишүүд: С.Баясгалан

Ө.Сарангэрэл

## Агуулга

<b>Товчилсон үгийн тайлбар .....</b>	<b>4</b>
<b>I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт .....</b>	<b>5</b>
<b>II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга .....</b>	<b>6</b>
<b>III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт</b>	
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт .....	7
Шалгуур 2: Сургалтын үйл ажиллагаа .....	9
Шалгуур 3: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл .....	11
Шалгуур 4: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт .....	14
Шалгуур 5: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа .....	18
Шалгуур 6: Багшийн үйл ажиллагаа .....	21
Шалгуур 7: Чанарын үнэлгээ, баталгаажилт .....	24
<b>IV. Уулзалтад оролцогчдын нэрс</b>	
I. Багш нарын нэрс .....	30
II. Оюутнуудын нэрс .....	30
III. Ажил олгогчдын нэрс.....	30
IV. Төгсөгчдийн нэрс .....	31
<b>V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал</b>	
<b>VI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр</b>	
<b>VII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр</b>	

## Товчилсон үгийн тайлбар

- ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
- БСШУЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам
- ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
- ЭМШУИС	Эрүүл мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль
- АШУҮИС	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний их сургууль
- ХӨСҮТ	Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв
- ТТАХНЭ	Төрийн Тусгай Алба Хаагчдын Нэгдсэн Эмнэлэг
- ОУЭБЭЭНН	Олон улсын эх баригч эмэгтэйчүүдийн эмч нарын нийгэмлэг
- БХТ	Багшийн Хөгжлийн Төв
- АУС	Анагаах Ухааны Сургууль
- СС	Сувилахуйн Сургууль
- ЭЗУЧТ	Эмнэл зүйн ур чадварын төв
- МУ	Монгол улс
- СБЗГ	Сургалтын Бодлого Зохицуулалтын Газар
- АГ	Амаржих газар
- ЭХЭМҮТ	Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв
- ЭМТ	Эрүүл Мэндын Төв
- НЭ	Нэгдсэн эмнэлэг
- ИС	Их сургууль
- ОУ	Олон улс
- ЭШ	Эрдэм шинжилгээ
- БГД	Баянгол дүүрэг

## I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт


<b>Сургуулийн нэр /Монгол, Англи/</b>	АШУҮИС – ийн Сувилахуйн сургууль	
<b>Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/</b>	Эх барихуй	
<b>Индекс</b>	091302	
<b>Шинжээчид</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. С.Эрдэнэтуул – Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Академик чиглэл хариуцсан дэд захирал, шинжээчийн багийн ахлагч</li> <li>2. Ө.Сарангэрэл – Этүгэн их сургуулийн Сувилахуйн сургуулийн Төрөлжсөн сувилахуйн тэнхимийн эрхлэгч, шинжээчийн багийн гишүүн, Клиникийн профессор</li> <li>3. С.Баясгалан – Хүнлэг эмэгтэйчүүдийн эмнэлэгийн зөвлөх эмч, шинжээчийн багийн гишүүн, Клиникийн профессор</li> </ol>	
<b>БМИҮЗ-ийн Мэргэжилтэн</b>	БМИҮЗ-ийн Ажлын албаны ахлах мэргэжилтэн Б.Мядагмаа	
<b>Төлөвлөгөө</b>	<b>Он сар өдөр</b>	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	11.30 – 12.07	Өөрийн үнэлгээний тайлантай танилцах
	12.09	Урьдчилсан үнэлгээний дүгнэлтийг сургуульд хүргүүлэх
	12.11 – 12.12	Сургуульд дээр ажиллаж, нотолгоо баримтуудтай танилцах
	12.19	Шинжээчийн багийн дүгнэлтийг сургуульд хүргүүлэх
<b>Шалгуур шаардлага /журам/</b>		

## II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Анх 1936 оноос эх баригчийг 6 сараас 1 жилийн хугацаагаар курсээр бэлтгэж эхэлсэн бөгөөд Засгийн газрын 1950 оны 6 сарын 17 -ны өдрийн 153/34 тоот тогтоолоор 1950-51 оны хичээлийн жилээс эхлэн эх барих бага эмчийн ангийг шинээр нээж хичээллүүлэх болсон. 1985 онд АУДуС – ийн сувилагчийн ангийг өргөтгөн сувилагчийн сургуулийг шинээр байгуулан АУДуС – ийн мэргэжлийн ангиудыг хаасанаар 1990 – 2001 оны хооронд эх баригч бэлтгэх үйл ажиллагаа тасарсан. 2001 оны 9 сарын 1 – нээс АУ – ны коллежид эх баригчийн ангийг дахин нээж, эх баригч нарыг бэлтгэж эхэлсэн. Сувилахуйн сургууль нь 2017 он хүртэл эх баригчийг дипломын боловсролтой бэлтгэж байсан бөгөөд ЭМ – ийн сайдын 2012 оны 05 дугаар сарын 19 – ны өдрийн 183 дугаар тушаалын 19,20 дугаар хавсралтаар эх баригчийн ажлын байрны тодорхойлолтын шинэчилсэн хувилбарт эх баригчид тавигдах шаардлага дээр бакалавр боловсролтой байна гэж заасны дагуу бакалаврын зэргийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

Эх барихуйн бакалаврын хөтөлбөрийг боловсруулахдаа хөтөлбөрөөр суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлагыг цогц байдлаар тодорхойлж, нийт 8 бүлэг бүхий 129 мэдлэг, 200 чадамж, 31 хандлагыг олгохоор тусгажээ. Эх баригчийн цогц чадамжийг Франц улсын Безонсан сургуулийн эх баригчийн цогц чадамжтай харьцуулан сайжруулжээ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах орчны стандартад сүүлийн жилүүдэд ихээхэн анхаарал хандуулж, ур чадварын лабораторийг байгуулан ашиглалтад оруулсан байна.

НҮБ-ын ХАС Люксембургийн Засгийн газар, МУЗГ хамтарсан санхүүжилттэй 150,000\$ ЭЗУЧТ байгуулсан. Дэвшилтэт технологи, компьютерт суурилсан SIMMOM болон бусад симуляци, муляж , тоног төхөөрөмж /хяналтын систем бүхий/ сургалтын орчинг бүрдүүлсэн нь энэхүү хөтөлбөрийн хувьд том давуу талыг бүрдүүлжээ.



### **III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт**

#### **Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт**

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

##### **1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага**

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч, сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

##### **Илрэл нотолгоо:**

- Ажлын байранд гарч буй өөрчлөлттэй холбоотой судалгаанууд, ажлын байранд тавигдах цогц чадамж
- Францын их сургуулийн ижил чиглэлийн сургалтын хөтөлбөртэй харьцуулсан судалгаа
- Эрүүл мэндийн салбарт 1-3 шатлалын эмнэлгүүдэд ажиллаж буй эх баригч нарын судалгаа
- Ажил олгогч, салбарын мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулсан хэлэлцүүлгүүдийн протокол, гаргасан шийдвэрүүд
- АШУҮИС-ийн хөтөлбөрийн бодлого, төлөвлөлттэй холбоотой эрх зүйн баримт бичгүүд

##### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Гадаадын их дээд сургуулиуд болон эрүүл мэндийн салбар дахь олон улсын хамтын ажиллагааны хүрээнд хөтөлбөрийн харьцуулалтыг хийснээс гадна төслийн хүрээнд хөтөлбөрийн агуулгад шинэчлэл хийсэн байна.
- Үндэсний хэмжээнд боловсруулагдсан бодлогын баримт бичиг, тухайн салбарт тавигдаж буй стандартын судалгааг хангалттай хийсэн байна.
- Ажлын байранд тавигдах шаардлага, үр чадварыг шинээр тодорхойлсон байна.

##### **Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрт оролцогч талуудаас авсан судалгааны нэгдсэн сан бүрдсэн эсэх нь тодорхойгүй байна.

##### **Зөвлөмж:**

- Оролцогч талуудаас авч буй судалгааны нэгдсэн санг Сувилахуйн сургууль дээрээ бүрдүүлэх, үр дүнг нэгжүүд хэлэлцэж хэвших

##### **1.2 Хөтөлбөрийн зорилго**

Хөтөлбөрийн зорилго нь үндэсний мэргэшлийн хүрээ, байгууллагын эрхэм зорилго, зорилт, холбогдох мэргэжлийн салбар болон оролцогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцсэн байна.

**Илрэл нотолгоо:**

- АШУҮИС-ийн хөгжлийн бодлогын баримт бичиг, Сувилахуйн сургуулийн стратеги төлөвлөгөө, алсын хараа, эрхэм зорилго
- Сургалтын хөтөлбөр
- Хөтөлбөрийн шинэчлэлтэй холбоотойгоор ажил олгогчид болон салбарын мэргэжилтнүүдтэй хийсэн уулзалт, хэлэлцүүлгийн протокол
- Сургуулийн веб хуудас

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан****Онцлог зүйл/Туршлага:**

- Хөтөлбөрийн зорилгыг тодорхойлоход ажил олгогчид болон салбарын мэргэжилтнүүдийн хэлэлцүүлгийг хийсэн байна.
- Ажлын байранд тавигдах ур чадварын стандартыг тодорхойлоход оролцоотой байна.
- Сургалтын хөтөлбөрийг боловсруулахад SPICES загварт тулгуурлан тодорхой арга зүйн үндсэн дээр боловсруулалт хийгдсэн байна.
- Хэрэглэгчийн шаардлагад нийцсэн, инновацийг хэрэгжүүлэгч сувилахуйн жишиг сургууль болно гэсэн

**Анхаарах асуудал:**

- Төгсөгчдөд хөдөлмөрийн зах зээлийн эрэлтээс хамаарсан эсвэл ажлын байран дээр хөрвөх боломжийг олгох

**Зөвлөмж:**

- Сонгох хичээлүүдийн боломжийг нэмэгдүүлэх замаар хөрвөх ур чадварыг эзэмшүүлэх

**1.3. Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд**

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга, сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй, сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тусган тогтмол сайжруулдаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Сургалтын хөтөлбөр
- Хичээлийн хөтөлбөрүүд
- Ур чадварын матриц
- Үнэлгээний рубрикүүд
- Сургалтын журам, цахим сургалтын журам, хөтөлбөрийн хорооны журам

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан****Онцлог зүйл/Туршлага:**

- Сургалтын хөтөлбөрийн баримт бичгийн баталгаажилт нэгдсэн стандартын дагуу бүрдсэн.
- Хичээлүүдийн хөтөлбөр нэгдсэн удирдамжийн дагуу боловсруулагдсан.
- Хөтөлбөрт тодорхой давтамжтайгаар сайжруулалт хийж хэвшсэн байна.

- Хичээлийн хөтөлбөрт хичээлээр олгох мэдлэг, чадвар, хандлага, тухайн чадамжийг ямар сэдвүүдээр олгох, сургалтын арга хэлбэрийг ашиглах, үнэлгээний арга, хичээлийн зорилтот суралцахуйн үр дүнгийн хөтөлбөртэй уялдах уялдаа зэргийг тодорхойлсон байна.
- Сургалтын төлөвлөгөөний бүтэц БСШУ-ны сайдын А/174 тоот тушаалын “Бакалаврын хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлага”-ыг хангаснаас гадна хөтөлбөрийн баримт бичгийн бүрдэл энэхүү шаардлагыг хангасан байна.
- Сургалтын хөтөлбөрийг 2012 онд 3 удаагийн 2014 онд 1 удаагийн хэлэлцүүлэг хийж, шинэчилснээс гадна 2016 онд АШУҮИС-ийн нэр томъёоны зөвлөлөөр хэлэлцүүлэн баталж, 2017-2019 оны хичээлийн жилд дахин шинэчлэн сайжруулж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Хичээлүүдийн өмнөх холбоо хичээлийн хөтөлбөрт тавигдсан нь сургалтын төлөвлөгөөтэй зарим газар зөрж байсныг засах.

#### **Зөвлөмж:**

- Хичээлийн өмнөх холбоог оюутанд ойлгомжтой байдлаар зааж өгөх.

#### **1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

#### **Шалгуур 2. Сургалтын үйл ажиллагаа**

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

#### **2.1 Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл**

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургалтын хөтөлбөр
- Дадлагын удирдамж
- Сургалтын болон цахим сургалтын журам
- Ерөнхий суурь хичээлийг зохицуулах журам
- Хичээлийн хөтөлбөрүүд
- Тестийн материал, Moodle системд байршуулсан хичээлүүд

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага**

- Ерөнхий суурь хичээл нь агуулгын өргөн хүрээг хамарсан харилцааны ур чадвар, бичих, илтгэх ур чадвар, гадаад хэлний суурь чадварыг оюутанд олгоход чиглэгдсэнээс гадна сонгох хичээлүүдээр эдийн засгийн болон экологийн зэрэг бусад салбарын суурь мэдлэг, чадварыг олж авах боломжийг олгосон байна.
- Хичээлүүд нь лекц, семинар, дадлагын хэлбэрээр зохион байгуулагдсан онол, практикын хосолсон хэлбэртэй. Дадлагын түшиц баазтай.



- Оюутанд практик чадвар олгоход чиглэгдсэн сургалтын хэрэглэгдэхүүнүүдийг төслийн хүрээнд хангалттай бэлтгэж, ур чадварын лабораторийг байгуулсан байна. Энэ нь сургалтын виртуаль орчин болж, хөтөлбөрт тусгагдсан цогц чадамжийг оюутанд олгох боломжийг бүрдүүлж байна.

**Анхаарах асуудал:**

- Хөтөлбөрийн ур чадварын матрицыг хийхдээ түвшингүүдийг ялгаж харуулаагүй байна.

**Зөвлөмж:**

- Хөтөлбөрөөр олгох цогц чадамжийг тодорхойлж, матрицыг хийхдээ ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх гэсэн 3 бүлгээр тусад нь тодорхойлсныг нэгдсэн зураглал гаргаж харах
- Матрицыг тодорхойлохдоо ур чадварын түвшинг ялгаж харуулах.

**2.2 Сургалтын арга зүй**

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

**Илрэл нотолгоо:**

- Сургалтын хөтөлбөр
- Хичээлийн хөтөлбөрүүд
- Бие даалтын удирдамж
- Дадлагын удирдамж
- Цахим сургалтын журам

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Лекцийн хичээлд уламжлалт болон интерактив аргыг хослуулан ашигладаг бол, семинарын хичээлд оюуны зураглал гаргах, багаар ажиллуулах, дүрд тоглох, хэлэлцүүлэг өрнүүлэх аргыг өргөн ашиглаж байна.
- Ерөнхий суурийн болон сонгон хичээлүүдийн лекцийг онлайн хэлбэрт шилжүүлж, оюутан зайнаас суралцах нөхцлийг бүрдүүлсэн байна.
- Дадлага ажлын хувьд муляж дээр үлгэрлэн үзүүлэх, орны дэргэдэх сургалт, эмнэлзүйн тохиолдол дээр ажиллах аргуудыг хослуулан ашиглаж байна.
- Хөтөлбөрт тусгагдсан мэдлэгийг аман болон бичгийн хэлбэрээр шалгадаг бол, ур чадварыг OSCE болон OSPE хэлбэрээр зохион байгуулж байна.
- Хичээлийн хөтөлбөрт бие даалт, дадлага ажлын удирдамж, семинарын удирдамж зэргийг бүрэн тусгасан байна.

**Анхаарах асуудал:**

- байхгүй

**Зөвлөмж:**

- байхгүй

**2.3 Суралцагчийн үнэлгээ**

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн үнэлдэг арга зүйтэй, тасралтгүй сайжруулдаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Үнэлгээний журам
- Хичээлийн хөтөлбөр, хөтөлбөрт тусгагдсан үнэлгээний арга зүй
- Тестийн сан
- Шалгалтын арга хэлбэрүүд гарын авлага

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Оюутны мэдлэг, чадварыг үнэлэх үнэлгээний маш олон аргыг хослуулан ашиглаж байна.
- Төгсөлтийн ур чадварын шалгалтын талаарх төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгааг авч дүгнэсэн байна.
- Шалгалтын материалын хүнд хөнгөний зэрэг, хөтөлбөрийн нийцэл зэрэгт сургалтын бодлого, зохицуулалтын газар үнэлгээ хийж байна.

### **Анхаарах асуудал:**

- Суралцагчийн ахиц дэвшилд хийсэн судалгаа байхгүй байна.

### **Зөвлөмж:**

- Дүнгийн шинжилгээ болон орц, гарцын үнэлгээнд дүн шинжилгээ хийж хэвших
- Хичээл бүрийн үнэлгээнд дүнгийн шинжилгээ хийдэг боловч, нэгдсэн байдлаар санг бүрдүүлж, шинжилгээ хийж хэвших, хурлаар хэлэлцэх

### **2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 3. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл**

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн байна.

#### **3.1 Сургалтын орчин**

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Сургалтын барилга байгууламж нь стандартад заасан байр, талбайн хэмжээ, эрүүл ахуйн нормативыг хангасан .
- Анги, танхим, лабортаориудын талбайн болон бусад үзүүлэлтүүдийн мэдээлэл
- Дадлагын бааз түшиц эмнэлэгтэй байгуулсан гэрээ
- Хамтын ажиллагааны гэрээтэй байгууллагуудын жагсаалт, шинэчлэн байгуулсан гэрээнүүд

- Эмнэлзүйн ур чадварын төвийг байгуулсан тухай тушаал, шийдвэрүүд, ур чадварын төвийн тоног төхөөрөмжүүдтэй ажиллах гарын авлага, удирдамж
- Сургууль дээр хэрэгжсэн ОУ-ын төслүүд, эдгээрийн хэрэгжилтийн тайлангууд

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- 2017 оноос “Эх нярайн зайн оношилгооны дэмжлэг үзүүлэх” төслийг хэрэгжүүлснээр шинэ ЭЗУЧТ-ийг ашиглалтанд оруулж сургалтын симулятор, муляж, багаж хэрэгслээр хангахад 150000 ам долларын хөрөнгө оруулалт хийгдээд байна.
- Улсын эмнэлгүүд болон дүүргийн эрүүл мэндийн төвүүд, хувийн эмнэлгүүд гээд тухайн салбарын байгууллагуудтай хамтын ажиллагааны гэрээний үндсэн дээр оюутнаа дадлагажуулах, сургалт, эрдэм шинжилгээнд татан оролцуулах нөхцлийг хангасан.
- Дадлагын бааз, түшиц эмнэлэгтэй.

#### **Анхаарах асуудал:**

- Эмнэлгүүдтэй байгуулсан гэрээний хугацааг анхаарах.
- Эмнэлгүүдийн нэрийг зөв бичих (Жишээ нь: Цэргийн төв эмнэлэг, Хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлэг)

#### **Зөвлөмж:**

- ЭЗУЧТ-д байгаа муляж, симулятор, багаж тоног төхөөрөмжийг сайтар ашиглах
- Оюутнуудаас сэтгэл ханамжийн судалгааг улирал тутам, ядахдаа хагас жил тутамд авч дүн шинжилгээ хийж, үйл ажиллагаандаа тусгах

### **3.2. Сургалтын хэрэглэгдэхүүн**

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Ур чадварын болон бусад лабораториуд
- ОУ-ын төслийн хүрээнд хийгдсэн ажлуудын тайлан
- Санхүүгийн тайлан, түүнд тусгагдсан зардлын үзүүлэлтүүд
- Онлайн сургалтын хэрэглэгдэхүүн, мүүдл систем
- Сэтгэл ханамжийн судалгааны тайлан
- Сорилын сан /хэвлэмэл болон цахим хэлбэрээр/
- 2013 оноос бүх багш, ажилчдын хэрэгцээнд албан ёсны лицензтэй Microsoft Windows 7,8,10 үйлдлийн системийг ашиглаж байна.
- Kaspersky Edpoint security10 албан ёсны лицензтэйгээр ашиглаж байна.
- Одоогоор 40 хичээлийн явцын болон төгсгөлийн 3400 гаруй сорилыг програмд байршуулан эх баригч мэргэжлийн төгсөлтийн онолын шалгалтыг 2017 оноос эхлэн

Moodle системийг ашиглан авч байгаа ба жил бүр баяжуулалт хийгдэн 520 сорилын фондтой болоод байна.

- 2014 онд чанд авиан шинжилгээний аппарат (1), эх барихын тусламжийн багажууд (15), хүүхдийн (1), насанд хүрэгчидийн (1) амбу авсан.
- Сэтгэл ханамжийн судалгаанд 157 оюутан хамрагдаж ном хэрэгслийн хэрэгцээ 89%, техник хэрэгслийн хэрэгцээ 92%, мэргэжлийн номын хүрэлцээ 89% хангалттай гэж үнэлгээ өгсөн.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Эмнэлзүйн сургалтанд ашиглагдах тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, дадлагажих эмнэлэг хангалттай
- ОУ-ын төслүүдийн хүрээнд оюутны суралцах виртуаль орчин бүрдэж, оюутан дадлага хийх муляж болон бусад хэрэгслүүдээр сайн хангагдсан.
- Оюутны суралцахуйн үр дүнг маш олон аргыг хослуулан үнэлдэг бөгөөд сорилын болон тестийн сан сайтай.

#### **Анхаарах асуудал:**

- Шинээр байгуулсан ур чадварын лабораторийг бүрэн дүүрэн ашиглах, арга зүйч нарыг бэлдэх тал дээр анхаарах.

#### **3.3. Номын сан, мэдээллийн эх үүсвэр**

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт ном сурах бичиг, мэдээллийн эх үүсвэрээр тогтмол, чанартай хангадаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Номын сангийн үйлчилгээний журам
- Номын сангийн программ / АУ-ны төв номын сан Коһа програмыг ашиглах болсон тул 2017 оноос эхлэн тус програмыг ашиглаж эхэлсэн ба програмд одоогоор 20627 номын мэдээллийг оруулаад байна
- Номын фондын баяжилтын мэдээлэл /2013-2018 онуудад нийт 1569 ном, сурах бичгийг сургалтанд ашиглахаар шинээр авсан байна.
- Цахим номын сан, түүний баяжилтын байдал
- Судалгааны нээлттэй сангууд, багш нарын ашиглалтын байдал
- Номын санд ашиглаж буй мэргэжлийн ном, сурах бичгийн жагсаалт болон номын фондын баяжилтын мэдээлэл
- Цахим хэлбэрээр англи хэлээр 120, монгол хэлээр 20 номыг уншигчдад хүргээд байна.
- Цахим уншлагын танхимаар үйлчлүүлсэн оюутны тоо 2012 онд 2588, 2015 онд 4824 байсан бол 2018 онд 44485 болсон байна.
- Шинээр авсан номын сэдэвчилсэн үзэсгэлэнг гаргаж, фонд бүрдүүлэлтээр ирсэн номыг цахим хуудсаар сурталчилж байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Номын сангийн Коһа программыг ашиглаж, тус программд мэргэжлийн чиглэлийн 20627 номын мэдээллийг оруулсан байна.
- 2019 онд 3900000 төгрөгний өртөг бүхий номын баяжуулалтыг хийсний дотор эх барих, эмэгтэйчүүдийн чиглэлийн ОУ-ын стандарт сурах бичгийг худалдан авч, багш нарын баг орчуулга дээр ажиллаж байна.

### **Анхаарах асуудал:**

- Номын сангийн Коһа программын ашиглалтын талаар оюутнуудын ойлголт тааруу байгаад анхаарч, тэдэнд сурталчлан таниулах
- Цахим номын сангийн хэрэглээг дэмжих
- Нээлттэй сангуудыг оюутнууд ашиглах боломжийг нэмэгдүүлэх

### **Зөвлөмж:**

- Коһа програм, цахим номын санг оюутнуудад сурталчилж, байнга хэрэглүүлж сургах
- Эх барихуйн чиглэлээр сурч байгаа оюутнуудад мэргэжлийн сурах бичгийг өөрсдийн боломжид тулгуурлан зохиох, тодорхой хугацаанд шинэчилж байх
- Судалгааны нээлттэй сангуудын талаар оюутнуудад сурталчлан таниулж, хичээлд хэрэглэх боломжийг олгох

**3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **Шалгуур 4. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт**

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

### **4.1. Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа**

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

### **Илрэл нотолгоо:**

- Хөтөлбөрийн хороо, профессорын багийн ажиллах эрх зүйн орчны баримт бичгүүд
- Хөтөлбөрийн шинэчлэлт, сайжруулалттай холбоотой ажлын төлөвлөгөө, хурлын тэмдэглэлүүд
- Хөтөлбөрийг үнэлэх үнэлгээний асуумж, судалгааны тайлан
- Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор хэлэлцсэн 3 удаагийн хэлэлцүүлгийн тэмдэглэл, гарсан шийдвэрүүд
- Эх баригчийн цогц чадамжийг тодорхойлох чиглэлээр хийсэн тэнхимийн 9 удаагийн хурлын болон оролцогч талуудтай хийсэн 2 удаагийн уулзалтын тэмдэглэл
- Эх баригчийн ажлын байрны тодорхойлолтыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилэн боловсруулсан.
- Удирдлагын мэдээллийн систем, түүний хэрэглээ
- Сургууль, тэнхимийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хийсэн SWOT шинжилгээ, үр дүнгийн тайлангууд

- Тэнхим дээр хэрэгжсэн төслийн мэдээллүүд, холбогдох тайлангууд

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Мэргэжилтний цогц чадамж, ажлын байрны тодорхойлолт боловсруулж баталгаажуулсан
- 6 төсөл хэрэгжүүлж багш, оюутан солилцоонд хамрагдан зохих үр дүнд хүрсэн
- ЭЗУЧТ-ийг иж бүрэн тоноглож, тохижуулсан
- SWOT үнэлгээ хийсэн

#### **Анхаарах асуудал:**

- Оролцогч талуудын санал, сэтгэл ханамжийг тодорхойлох судалгааг нэгж өөрөө хийх эсвэл үр дүнг хэлэлцэн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгадаг байх.

#### **4.2. Хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ**

Дотоодын болон олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагууд, төрийн болон ТББ-тай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэг ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Гадаадын их дээд сургуулиуд болон ОУ-ын байгууллагуудтай байгуулсан хамтын ажиллагааны гэрээ
- Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд багш солилцоо, оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдсан багш, оюутнуудын мэдээлэл, төслийн тайлангууд
- Хамтран ажиллаж буй ТББ, МЭБН-үүдийн талаарх мэдээлэл, хамтран зохион байгуулсан сургалт, судалгааны тайлангууд
- Орон нутагт чиглэсэн 2 удаагийн сургалтын төлөвлөгөө, тайлангийн материалууд
- Тус сургуулийн төгсөгчдийн холбоо нь АШУҮИС-ийн төгсөгчдийн холбооны бүрэлдэхүүнд хамрагдаж үйл ажиллагааг хамтран явуулдаг, төгсөгчдийн холбоо нь ЭМХөгжлийн төвтэй хамтран төгсөлтийн дараах сургалтуудыг 2015 онд 2 удаа, 2016 онд 2 удаа, 2017 онд 3 удаа, 2018-2019 онуудад 1 удаа нийт 13 багц цагийн сургалтыг явуулж 4300 төгсөгчид оролцжээ.
- Төгсөгчдийн ажил эрхлэлт 95% байгаа ба төгсөгчдөөс 18 эх баригчийг төгсөлтийн дараах клиникийн дадлагын сургалтанд хамруулж, сургагч багшаар бэлтгэсэн, эдгээрээс 3 эх баригч тус тэнхимд гэрээт багшаар ажиллаж байна.

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Гадаадын 7 их сургуультай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, багш оюутнуудыг богино хугацааны оюутан солилцооны хөтөлбөрт хамруулж байна.
- Сүүлийн 5 жилд 20 гаруй төсөлд хөтөлбөрийн багийн багш нар оролцож, багш оюутан солилцоогоор 17 багш гадаадаас ирж, өөрийн сургуулийн 21 багш, 7 оюутан 7-45 хоногийн хугацаагаар сургалтанд хамрагдсан байна.
- ТББ-тай хамтран нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр үзүүлэх сургалт 3 удаа, боловсрол олгох сургалтыг 2 удаа зохион байгуулсан байна.

- Хөдөө орон нутагт МЭБН-тай хамтран 2 удаагийн сургалтыг зохион байгуулж, 800 гаруй хүнд хүрч ажиллажээ.

#### **Анхаарах асуудал:**

- Хөдөө орон нутагт ажиллаж байгаа төгсөгчдийн ажил эрхлэлт, төгсөлтийн дараах сургалтанд хамруулах, төгсөгчидтэйгээ холбоо тогтоох, төгсөгчдийн холбооны ажлыг жигдрүүлэхэд анхаарах

#### **Зөвлөмж:**

- Төгсөгчдийн холбоог албажуулан үйл ажиллагааг эрчимжүүлэх боломжийг олгох

#### **4.3 Санхүүжилт**

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Жилийн нийт орлого 2017-2019 онд 1,321,097,5 нийт зардал 880,870,8 төгрөг
- Үйл ажиллагааны зардал сургалтын орчны тохижилтонд 2017-2019 онд 106,445,761 төг, хичээлийн хэрэглэгдэхүүн, урсгал зардал 155,602,00 төг, өөрийн төсвийн 73,000,000 төг зарцуулсан
- Хөтөлбөрийн хүрээнд төсвийг сургалтын хэрэглэгдэхүүн, үзүүлэн таниулах материал, оюутны болон багшийн хөгжил, гадаад харилцааг сайжруулах, эмнэл зүйн үр чадварын төвийн тохижилтонд зарцуулсан.

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Эх барихуйн чиглэлээр сургалт явуулж буй улсын ганц сургууль учир гадаадын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх боломж өндөр, төслийн санхүүжилт ч өндөр байна.
- Сургалтын орчныг сайжруулах, материаллаг баазыг бэхжүүлэх чиглэлээр сүүлийн 3 жилд 73.0 сая төгрөг өөрийн төсвөөс зарцуулсан байна.

#### **Анхаарах асуудал:**

- Сургалтын төлбөрөөс бусад орлогыг нэмэгдүүлэх, орлогыг солонгоруулах боломжийг нэмэгдүүлэх

#### **Зөвлөмж:**

- Багш нарын судалгаа хийх боломжийг нэмэгдүүлэх замаар судалгааны орлогыг нэмэгдүүлэх боломжийг хайх

#### **4.4. Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт**

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургуулийн стратеги төлөвлөгөө, идэвхжүүлэлттэй холбоотой үйл ажиллагааны төлөвлөгөө, холбогдох тайлангууд
- БСШУЯ, МИДСК-аас зохион байгуулдаг “Боловсролын үзэсгэлэн яармаг”-т оролцсон тайлангууд

- Мэргэжил сурталчлах видео танилцуулга
- Багшийн чуулга уулзалт, багш шавийн уулзалтын тэмдэглэлүүд
- МЭБН-тэй хамтран мэргэжил сурталчлах өдөрлөгүүд зохион байгуулсан тухай ажлын тайлангууд

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- АШУҮИС -ийн нэгдсэн бодлогоор идэвхжүүлэлтийн хөтөлбөр, элсэлттэй холбоотой үйл ажиллагаанууд зохицуулагддаг.
- Сургуулийн нэгдсэн веб хуудсаар бүхий л мэдээллийг оролцогч талуудад хүргэдэг.
- 2013 оноос хойш “Олон улсын эх баригчдын өдөр”-өөр мэргэжил сурталчлах ажлуудыг тогтмол зохион байгуулж байна.
- Багш шавийн уулзалтыг төгсөгчдийн холбоотой хамтран зохион байгуулж хэвшсэн.

#### **Анхаарах асуудал:**

- Нэгж өөрийн идэвхжүүлэлтийн хөтөлбөр, элсэгчдийн чанарт дүн шинжилгээ хийж хэвших

#### **4.5. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал**

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургуулийн веб хуудас
- Сургуулийн дотоод удирдлагын мэдээллийн систем
- Мэргэжлийн клубууд, тэдгээрийн үйл ажиллагааны төлөвлөгөө
- Сургуулийн зүгээс гаргасан хэвлэмэл материалууд, сонин

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- АШУҮИС-ийн цахим хуудас, Unimis программ, мэдээллийн сайтыг тогтмол ажилуулдаг
- Мэргэжлийн 2 клуб тогтмол ажилладаг
- Оюунлаг залуус сонин, сэтгүүл 2 удаа, оюутанд зориулсан гарын авлага, эмнэл зүйн гарын авлагууд боловсруулсан

#### **Анхаарах асуудал:**

- Сургуулийн нэгдсэн веб хуудсаар өдөр тутмын мэдээллийг тэр бүр дамжуулах боломжгүй тул, өөрийн веб хуудсыг хөгжүүлэх

#### **Зөвлөмж:**

- Хөтөлбөр өөрийн мэдээллийг цаг алдалгүй шуурхай хүргэж байхын тулд социал сүлжээг ашиглах, өөрийн тэнхимийн веб хуудсыг ажиллуулж болох юм.

### **4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

## **Шалгуур 5. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа**



Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

### **5.1. Суралцагч сонгох, элсүүлэх**

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Элсэлтийн журам
- Шинэ суралцагчийг элсүүлэхтэй холбоотой процессийн зураглал
- Онлайн бүртгэлийн систем
- Элсэлтийн тушаал
- Элсэгчдэд тавигдах шалгуур, шаардлага, босго оноо
- Чиглүүлэх хөтөлбөр
- Оюутанд зориулсан оюутны гарын авлага болох оюутны хөтөч ном
- Элсэгчдийн ЭЕШ-ийн онооны байдалд хийсэн шинжилгээ

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Жил бүр шинээр элсэн орсон элсэгчдэд тухайн сургуулийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл, мэргэжлээрээ бахархах, мэргэжлийн үнэ цэнийн талаарх онцлог бүхий хичээл, лекцүүд сургуулийн дотоод дүрэм журам, хүнлэг ёс, ёс суртахууны талаар 7 хоногийн турш тусгайлан гаргасан хуваарийн дагуу хичээл заадаг.
- Элсэлтийн эрх зүйн орчинг АШУҮИС-ийн бодлогын хүрээнд төв сургууль тодорхойлдог учир, энэ бодлогод нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулдаг.
- Элсэгчдийн хими болон биологийн хичээлээрх элсэлтийн шалгалтын дундаж оноо өсөх хандлагатай байгаа бөгөөд 500-аас дээш байна.

#### **Анхаарах асуудал:**

- Оюутнуудын гадаад хэлний ур чадвар болон бусад суралцахуйн зорилтот үр дүнг олгоход шаардлагатай суурь чадамжуудыг хэрхэн хэмжихэд анхаарах.

#### **Зөвлөмж:**

- Оюутны хөтөч ном АШУҮИС-ийн хэмжээнд хэвлэгдэн оюутны гар дээр хүрч байгаа боловч, тухайн хөтөлбөрөөр судлах хичээлүүд, сонгох хичээлүүдийн талаарх мэдээллийг авах гарын авлага сүүлийн жилүүдэд хэвлэгдээгүй байгааг эргэн сэргээх.

### **5.2. Зөвлөн туслах үйлчилгээ**

Суралцагчид суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогтмол, чанартай үзүүлдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Зөвлөх багшийн тушаал, нэг багшид ноогдох оюутны тоо
- Сэтгэлзүйн төв байгуулсан тушаал, ажиллах журам

- Зөвлөх багшийн ажиллах хуваарь, оюутан хүлээн авах хуваарь
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвийн үйл ажиллагааны тайлан
- Оюутны клубуудын үйл ажиллагааны тайлан
- Сэтгэлзүйн төвөөр үйлчлүүлсэн оюутнуудын талаарх мэдээлэл, тайлан
- Оюутны өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хүлээн авах талаарх журам

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Анги удирдсан багш бүр зөвлөх багш гэх статустай ажилладаг. Нийт 60 зөвлөх багш ажиллаж байна.
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв байнгын үйл ажиллагаа явуулж, ажлын байранд суралцагчдыг бэлтгэх чиглэлээр сургалтуудыг зохион байгуулдаг. Нийт 44 оюутан цагийн ажил хийх хүсэлт гаргаснаас 18 нь цагийн ажлаар хангагдсан.
- Нийт оюутны 5 хувь нь сэтгэлзүйн төвөөр үйлчлүүлж, зөвлөх үйлчилгээг авсан.
- Оюутнуудыг дадлагад гарахаас өмнө заавал хийлгэх шаардлагатай шинжилгээнүүдэд хамруулж, шинжилгээний хариу өөрчлөлттэй гарсан нөхцөлд эмчилгээний зөвлөгөө өгөн ажиллаж байна.

#### **Анхаарах асуудал:**

- Суралцагчид, төгсөгчдийн сэтгэл ханамжийг заасан хугацаанд тодорхойлж, үр дүнг эргэн хэлэлцэж хэвших

#### **Зөвлөмж:**

- Судалгааны үр дүнг эргэж талуудад мэдээлэх, хийсэн ажлаа тайлагнах
- Зөвлөх багшийн үзүүлж буй үйлчилгээний талаар мэдээллийн санг бүрдүүлэх, оюутантай холбоотой гол төлөв ямар асуудлууд үүсч байгаад шинжилгээ хийж байх.

### **5.3. Суралцагчийн олон нийтийн оролцоо, урамшууллын тогтолцоо**

Суралцагчийн олон нийтийн үйл ажиллагаанд оролцох оролцоо, сайн дурын ажлыг дэмжиж хамтран ажилладаг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Сургуулийн стратеги төлөвлөгөө
- Оюутны зөвлөл, дотно туслагч клуб, үе тэнгийн зөвлөгч клубуудын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан
- Нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв, БГД-ийн хөдөлмөр эрхлэлтийн газартай байгуулсан гэрээнүүд
- Оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдсан оюутнуудын судалгаа
- Захирлын нэрэмжит тэтгэлэгт хамрагдсан оюутнуудын мэдээлэл

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Оюутны үе тэнгийн зөвлөгч клубын оюутнууд нь сүүлийн 3 жилд 14 үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд үйл ажиллагаа нь зөвхөн тухайн сургуулийн оюутнуудад чиглэсэн бус олон нийтэд чиглэсэн гадаад орчинд чиглэсэн өргөн хүрээтэй үйл ажиллагаа байдаг.
- Амжилттай сайн суралцаж буй оюутнуудын хувьд богино хугацаагаар гэрээтэй гадаадын их дээд сургуулиудын оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдах, гадаадад дадлага хийх боломжоор хангагддаг. Сүүлийн 5 жилд 6 оюутан гадаадад дадлага хийж, 9 оюутан оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдсан байна.

#### **Анхаарах асуудал:**

- Тэтгэлэгт хамрагдсан оюутнуудын тоо дэлгэрэнгүй тайлагнаж, бүртгэлжүүлж байх
- Клубуудын үйл ажиллагааны санхүүжилтийн асуудлыг шийдэх

#### **Зөвлөмж:**

- Тэтгэлэгт хамрагдах шалгуур шинж, тэтгэлгүүдийн тухай мэдээллийг оюутнуудад нээлттэй болгосноор оюутнуудын амжилттай суралцах тэмүүллийг нэмэгдүүлэх боломжтой.
- Клубуудын үйл ажиллагааны санхүүжилтийг тэнхимийн эсвэл оюутны зөвлөлийн нэгдсэн төсөвт суулган шийдэж өгөх.

#### **5.4. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн**

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам
- Шилжин ирсэн болон шилжин явсан оюутны бүртгэлийн мэдээлэл
- Шилжих хөдөлгөөний судалгаа
- Багц цаг дүйцүүлэн тооцох журам
- Хөтөлбөр солих болон шилжих хүсэлт гаргасан оюутны тоо, шийдвэрлэсэн байдал

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Суралцагчийн шилжих хөдөлгөөнтэй холбоотой эрх зүйн орчин АШУҮИС-ийн нэгдсэн бодлогоор тодорхойлогддог, дүрэм журмууд хангалттай боловсруулагдсан.
- Сургалтаас гадуур оюутны эзэмшсэн гадаад хэлний чадварыг багц цагт дүйцүүлэн тооцдог.
- Хүсэлт гаргасан оюутнуудын хувьд дүрэм журмын хэмжээнд 100 хувь шийдэгдсэн.
- Шилжилт хөдөлгөөн багатай, анх элссэн оюутан тухайн хөтөлбөрөөр төгсөх төгсөлтийн хувь өндөр.

#### **Анхаарах асуудал:**

- Шилжин явж буй оюутнуудаас шалтгааныг тодруулах, анализ хийх боломжийг бүрдүүлэх

**Зөвлөмж:**

- Шилжин явж буй суралцагсдаас шалтгааныг тодруулах, шилжин ирсэн суралцагсдын чанарт харьцуулсан судалгаа хийх

**5.5. Төгсөлтийн баримт бичиг**

Төгсөлтийн баримт бичиг нь оюутны мэргэшил, хувь хүний гүйцэтгэл, хөтөлбөрийн үр дүн, эзэмшсэн агуулга, түвшин зэргийг тусгасан байна.

**Илрэл нотолгоо:**

- Төгсөгчдөд олгож буй дипломын загвар
- Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл
- Төгсөлтийн шалгалтын журам
- Онцгойлох диплом олгох нөхцөл
- Төгсөлтийн тушаал

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

**Онцлог зүйл/Туршлага:**

- Төгсөгчдөд олгож буй диплом нь сургалтын тусгай зөвшөөрөлд заасан мэргэжлийн чиглэл, индексийг тусгасан байна.
- Төгсөлтийн ажлын зохион байгуулалт, төгсөлтөд тавигдах шаардлага АШУҮИС-ийн нэгдсэн бодлогоор зохицуулагддаг, эрх зүйн орчин тодорхой.

**5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

**Шалгуур 6. Багшийн үйл ажиллагаа**

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

**6.1. Багшийн сонгон шалгаруулалт, зэрэглэл, урамшууллын бодлого**

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

**Илрэл нотолгоо:**

- Багш бэлтгэх, сонгон шалгаруулах асуудал АШУҮИС-ийн захирлын 2016.11.06-ны А/118 тоот тушаалын 1-р хавсралтаар зохицуулагдан цэгцтэй хийгдэж байна.
- Багшийн аттестатчлалыг АШУҮИС-аас гаргасан журмын дагуу дадлагажигч багш жилд 1 удаа, багш 3 жилд 1 удаа, ахлах багш 5 жилд 1 удаа ажилаа үнэлүүлдэг
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нар 100% магистр, доктор зэрэгтэй багшийн эзлэх хувь 11%-аар өссөн
- АШУҮИС-ийн багшийн гүйцэтгэлийн үнэлгээний журмын дагуу жил бүр багш нараа үнэлж, урамшуулдаг
- Багш оюутны 1:14 зохистой харьцаатай
- 6-10 жил ажилсан багш 50%-ийг эзлэдэг, 3 гэрээт эх баригч багштай

**Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багшийн сонгон шалгаруулалт, хэрэгжилтийн талаар цогц бодлоготой
- Дүрэм журам, гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээ сайтай
- Багш нарын аттестатчлал, түүний шалгуур үзүүлэлтүүд нь тогтсон, багш нар энэ талаараа мэдлэг сайтай
- 1 багшид ноогдох оюутны тоо харьцангуй цөөн, зохистой харьцааг бүрдүүлж чадсан.

### **Анхаарах асуудал:**

- Доктор зэрэгтэй багшийн тоог нэмэгдүүлэх, судалгааны ажилд багш нарыг татан оролцуулах талаар санаачилгатай ажиллах

### **Зөвлөмж:**

- Докторантурт суралцаж буй багш нарын хамгаалах боломжит хугацааг төлөвлөн, цагийн ачааллын зохицуулалт хийх

## **6.2. Багшийн хөгжил**

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Багшийн хөгжлийн төвийн үйл ажиллагааны дүрэм, журмууд, төлөвлөгөө
- Багшийн хөгжлийн төвөөс авч явуулсан судалгааны тайлан
- Багшийн хөгжлийн хөтөлбөр
- Сургалтад хамрагдсан багш нарын мэдээлэл

### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

### **Онцлог зүйл/Туршлага:**

- АШУҮИС-ийн Багшийн хөгжлийн төвөөс сүүлийн 5 жилд 2 удаа судалгаа хийж, 2 хөтөлбөр хэргэжүүлж байна.
- Сүүлийн 5 жилд гадаадад 42, дотоодод 93 удаа туршлага судлаж 370 гаруй сургалтанд хамрагдсан.
- Багш хөгжлийн төвийн сургалтанд 87 багш, 45% мэргэжлийн, 32% сурган заах арга зүйн сургалтанд хамрагдсан.
- Багш нар төвөөс зохион байгуулж буй зарим төрлийн сургалтад зайнаас хамрагдах боломжтой.

### **Анхаарах асуудал:**

- Багшийн хөгжлийн төвөөс явуулж буй сургалтад хамрагдсан багш нарын тоо сүүлийн 3 жилд буурч байгааг анхаарах.

## **6.3. Эрдэм шинжилгээ, судалгаа**

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэргэжүүлэхэд үр нөлөөтэй байна.

### **Илрэл нотолгоо:**

- Сургуулийн стратеги төлөвлөгөө
- Багшийн хөгжлийн хөтөлбөр, түүнтэй холбоотой баримт бичгүүд
- Багш нарын аттестатчлалын журам
- Багш нарын ажлын гүйцэтгэл, ноогдол цагийн төлөвлөлт
- Багш нарын судалгааны бүтээлүүд
- Гадаадад, дотоодод туршлага судалсан багш нарын мэдээлэл
- Багш нарын мэргэжлийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- ЭШ судалгааны ажил эрхлэх гурвал бүтэц бүхий тогтолцоотой
- Судалгааны их сургууль болох зорилттой
- АШУҮИС-ийн хүрээнд ЭШС, төсөлд хөтөлбөрт бүрэн хамрагдаж шинэ туршилт хэрэгжүүлхэд багш нарын оролцоог нэмэгдүүлэн дэмжиж ажилдаг. Сүүлийн 5 жилд патент 7, зохиогчийн эрх 25, ашигтай загвар 3, 20 гаруй төсөлд хөтөлбөрийн багш нар оролцсон
- Сүүлийн 5 жилд хөтөлбөрийн багш нараас ОУ-ын нэр хүнд бүхий хэвлэлд 7 бүтээл, үндэсний хэвлэлд 80 бүтээл, ОУ-ын хэвлэлд 30 гаруй бүтээл хэвлэгдсэн

##### **Анхаарах асуудал:**

- Судалгааны үр дүнг сургалтад ашиглах, хөтөлбөрүүдэд судалгааны эх үүсвэрийг тусгах.

##### **Зөвлөмж:**

- Багш оюутны хамтарсан судалгааны багуудыг ажиллах боломжийг бүрдүүлэх, судалгааны төслийн үр дүнг олон нийтэд сурталчлах, судалгааны бүтээлүүдийг холбогдох сургалтын хөтөлбөрт тусгах.

#### **6.4. Багшийн үнэлгээ**

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

##### **Илрэл нотолгоо:**

- АШУҮИС-ийн Багшийн үйл ажиллагааг зохицуулах журмын дагуу багш бүр жил бүр тайлан бичиж БХ-ийн зөвлөлөөр үнэлүүлдэг
- Багшийн хөндлөнгийн үнэлгээний тайланг СБЗГ-аас баталсан комисс дүгнэж зөвлөгөө өгдөг
- Багш нар ажлын хавтастай ба хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөөг тэнхимийн эрхлэгчээр батлуулж сургалтыг явуулж хэвшсэн
- Багшийн бүх баримт бичиг тогтсон загвартай, үнэлгээний нэгдсэн программтай, энэ нь ил тод байдаг

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

##### **Онцлог зүйл/Туршлага:**

- Багшийн үйл ажиллагааг зохицуулах журмууд сайтай
- Багшийн ажлын үнэлгээ тодорхой болсон

- Багш нар сургалт, эрдэм шинжилгээний ажлыг гүйцэтгэхээс гадна мэргэжлийн үйлчилгээ, нийгэмд чиглэсэн үйлчилгээг үзүүлдэг, энэхүү ажлуудыг багшийн гүйцэтгэлд оруулан тооцдог.
- Багшийн үйл ажиллагаатай холбоотой бүх бичиг баримтууд тогтсон формат, үнэлгээний нэгдсэн загвартай

#### **Анхаарах асуудал:**

- Зарим багш нарын хувьд олон төрлийн мэргэжлийн хичээлийг заадаг, сургалтын ачааллаас шалтгаалан судалгаа хийх боломж хязгаарлагдмал.

#### **Зөвлөмж:**

- Нийгэмд чиглэсэн мэргэжлийн үйлчилгээ, сургалтуудыг гол төлөв хөдөө орон нутагт ажиллаж буй төгсөгчид руугаа чиглүүлэх
- Багш нарын судалгаа хийх боломжийг нэмэгдүүлэх тал дээр судалгааны тэргүүлэх чиглэлүүдээ тодорхойлон, тэнхим өөрөө тодорхой бодлоготойгоор ажиллах

**6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан**

### **Шалгуур 7. Чанарын үнэлгээ, баталгаажилт**

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

#### **7.1. Хөтөлбөрийн чанарын дотоод баталгаажуулалт, сайжруулалт**

Хөтөлбөрийг оролцогч талуудын оролцоотойгоор тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн үечилсэн чанарын дотоод болон хөндлөнгийн баталгаажуулалтын механизмтай байна.

#### **Илрэл нотолгоо:**

- АШУҮИС-ийн болон Сувилахуйн сургуулийн чанарын бодлого
- Суурь сургалтын хөтөлбөрийг зохицуулах журам
- Төгсөлтийн өмнөх сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам
- Сонгон суралцах хичээлийг зохион байгуулах журам
- Сургалтын технологи, чанарын хяналтын үлгэрчилсэн журам
- Сургалтын бодлого, зохицуулалттай холбоотой дүрэм журмын эмхэтгэл
- Сургуулийн бүтэц, зохион байгуулалт
- Олон улсын чанарын баталгаажуулалттай холбоотой баримт бичгүүд, процессийн зургууд

**Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Чанарын хяналтыг хийхэд 10 орчим дүрэм, журам үйлчилж байна.
- ISO9001 чанарын удирдлагын тогтолцоог 2016 оноос хойш хэрэгжүүлж байна.
- Чанарын баталгаажуулалтын процессын зураглал гарсан байна.

#### **Анхаарах асуудал:**

- Чанарын баталгаажуулалтын чиг үүргийн хуваарилалт ойлгомжгүй, оролцогч талуудаас авсан судалгааны нэгдсэн сан байхгүй байна.

- Чанарын баталгаажуулалтын нэгж байхгүй, багш нар давхар ажил үүргийн хэмжээнд гүйцэтгэж байна.
- Аудитор багш нарын үнэлгээ, урамшуулал тодорхойгүй байна.
- Оюутнуудаас ирж буй гомдол саналыг хайрцаар авдаг боловч, нэгдсэн судалгааны сан, оюутанд эргэж хариу өгсөн байдал, эргэх холбоо тодорхойгүй байна.

#### **Зөвлөмж:**

- Чанарын хяналтын шалгуур үзүүлэлтүүдийг тодорхой болгож, мэдээллийн санг бүрдүүлэх.
- Суралцагчдын, багш нарын, ажил олгогчдын, төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгааг тогтмолжуулан үр дүнг эргээд оролцогч талуудад мэдээлдэг байх.
- Журмуудын хэрэгжилтийн үнэлгээг хийх
- Чанарын баталгаажуулалтын алба, нэгжийн чиг үүргийг тодорхой болгох, ачааллыг тэнцвэржүүлэх

#### **7.2. Хөтөлбөрийн үр дүн**

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна..

#### **Илрэл нотолгоо:**

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа
- Ажил олгогчидтой зохион байгуулсан хэлэлцүүлгүүдийн протокол болон хамтран ажиллах санамж бичгүүд
- Төгсөлтийн шалгалтыг зохион байгуулахтай холбоотой дүрэм журмууд
- Төгсөлтийн шалгалтын болон явцын шалгалтын гарын авлага, тестийн сангууд

#### **Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан**

#### **Онцлог зүйл/Туршлага:**

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин 95 хувьтай
- Төгсөлтийн шалгалтыг өртөөчлөн зохион байгуулах өөрийн онцлог хэлбэрийг тогтмолжуулсан.

#### **7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх**

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

#### **Илрэл нотолгоо:**

- Дипломын боловсрол нь Үндэсний магадлан итгэмжлэлээр өмнө магадлан итгэмжлэгдэж байсан тул, түүнтэй холбоотой шинжээчдийн өгсөн зөвлөмж, зөвлөмжийн дагуу гүйцэтгэсэн ажлын тайлан
- Дэлхийн ЭМБ-ын стандарт, ОУ-ын түвшний бодлогын баримт бичгүүдийг өөрийн стратегид тусгасан байдал



- Францын их сургуулийн эх барихуйн хөтөлбөрийг өөрийн хөтөлбөртэй харьцуулан судалсан судалгааны материалууд

### Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

#### Онцлог зүйл/Туршлага:

- АРАСС-ийн гишүүн
- ОУ-ын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн сургуулийн ижил төстэй хөтөлбөрөөс бенчмаркинг хийн, хөтөлбөрийн агуулгад 40 гаруй хувийн шинэчлэл хийсэн.

#### Зөвлөмж:

- ОУ-д магадлан итгэмжлүүлэх ажлын эхлэлийг тодорхой хугацааны графиктайгаар төлөвлөн эрчимжүүлэх

### ДҮГНЭЛТ

	Шалгуур	Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангаагүй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	3			Шалгуур 1.1, 1.2, 1.3 гэсэн 3 дэд шалгуурыг бүрэн хангасан. Хөтөлбөрийн хэрэгцээ шаардлага нь нийгмийн хэрэгцээтэй уялдаж байгаагаас гадна хөтөлбөрийн зорилгыг АШУУИС – ийн стратегитай уялдуулан тодорхойлсон байна.
2	Сургалтын үйл ажиллагаа	3			Энэ бүлгийн 3 дэд шалгууруудыг бүрэн хангасан. Хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд хичээлүүдийн агуулгад шинэчлэлт хийж, хөтөлбөрийн баримт бичиг, хичээлийн хөтөлбөрийн дизайн, боловсруулалтыг нэгдсэн стандартын дагуу боловсруулж, баталгаажуулсан байна. Сургалтад онол, практикийг хослуулан ашиглахаас гадна цахим сургалтыг нэвтрүүлж, эхлүүлсэн байна.
3	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, нөхцөл	2	1		Шалгуур 3.1, 3.2 – бүрэн хангасан Шалгуур 3.3 – хэсэгчлэн хангасан Сургалтын орчны хувьд агааржуулалт тааруу байсан боловч, сургуулийн шинэ байр ашиглалтад орохоор төлөвлөгдөж байгаа тул, орчны нөхцлийг сайжирна хэмээн үзлээ. Сургалтын хэрэглэгдэхүүн, оюутнууд бие даан дадлага хийх боломж сайн бүрдсэн байна. Ур чадварын

					лаборатори нь энэ мэргэжлийн чиглэлээр улсдаа ганц байна. Номын сангийн үйлчилгээний хувьд цахим номын сан, номын сангийн программ нэвтэрсэн боловч, оюутнуудын энэ талаарх мэдээлэл, ашиглалт тааруу байна.
4	Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт	4			Энэ бүлгийн 5 дэд шалгуурыг бүрэн хангасан.
5	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	5			Энэ бүлгийн 5 дэд шалгуурыг бүрэн хангасан. Мэргэжлийн онцлогоос шалтгаалан суралцагсдын шилжилт хөдөлгөөн бага, АШУҮИС – ийн бодлогоор элсэлт болон төгсөлт бүх үйл ажиллагаа зохион байгуулагддаг.
6	Багшийн үйл ажиллагаа	4			Энэ бүлгийн 4 дэд шалгуурыг бүрэн хангасан. Багшийн сонгон шалгаруулалт, урамшууллын бодлого АШУҮИС – ийн нэгдсэн бодлогын хүрээнд зохицуулагддаг. Багшийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд багш нар тогтмол сургалт, хэлэлцүүлгүүдэд хамрагддаг. Багшийн ажлыг гүйцэтгэлээр нь үнэлэхээс гадна нэгжийн үнэлгээ хийж, жил бүр шилдэг тэнхимийг шалгаруулдаг. Тус тэнхим нь 2018 оны шилдэг тэнхимээр шалгарсан.
7	Чанарын үнэлгээ, баталгаажуулалт	2	1		Шалгуур 7.1 – хэсэгчлэн хангасан Шалгуур 7.2, 7.3 – бүрэн хангасан Төгсөгчдийн ажил эрхлэлтийн түвшин өндөр 95 хувьтай. Олон улсын чанарын баталгаажуулалтын ISO 9001 стандартыг хангасан боловч, оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгааны нэгдсэн санг бүрдүүлж, үйл ажиллагаандаа ашиглах тал нэгжийн хувьд дутагдалтай. Суралцагчдын гомдлыг авч буй боловч, шийдвэрлэсэн байдал болон ирц буй гомдол, саналуудад анализ хийгдээгүй байсан тул шалгуур 7.1 – хэсэгчлэн хангасан гэж дүгнэлээ.
	Дүгнэлт				7 шалгуур 100% - бүрэн хангасан

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн “Эх барихуй”-н бакалаврын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “Шалгуурыг бүрэн хангасан” гэж дүгнэж байна.

Шинжээчийн багийн дүгнэлтийг Эрүүл мэндийн чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг .....С.Эрдэнэтуул

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....Ө.Сарангэрэл

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг.....С.Баясгалан

### ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

1. Хөтөлбөрийн цаашдын сайжруулалтад хөтөлбөрөөр эзэмшүүлэх мэдлэг, чадвар, хандлагыг тодорхой түвшингүүдэд ангилан, хөтөлбөрийн матрицыг бүлэг бүлгээр бус нэгдсэн дүр зургаар нь тодорхойлох.
2. Суралцагчдын дүнгийн шинжилгээ хийж, сургалтын арга хэлбэрийн хувьд аль нь илүү тохиромжтой байгааг үнэлж үзэх
3. Эх барихуйн чиглэлээр мэргэжилтэн бэлтгэж буй цөөхөн сургуулийн 1 учир үндэсний хэмжээнд ашиглах сурах бичиг, гарын авлагыг сургуулиас гаргах тал дээр санаачилгатай ажиллах. Одоо ажиллаж буй орчуулгын сурах бичгийг бусад сургуулиудад ашиглах боломжийг олгох.
4. Номын сангийн үйлчилгээг хүртээмж сайтай болгох, гол нь оюутанд шинэ боломжуудыг сурталчлан таниулах, цахим номын сангийн хэрэглээг нэмэгдүүлэх, номын сангийн коха программтай оюутнуудыг ажиллаж сургах.
5. Чанарын баталгаажуулалтын алба, нэгжийн чиг үүргийг тодорхой болгож, оролцогч талуудаас авч буй сэтгэл ханамжийн судалгааны нэгдсэн санг тэнхим, салбар сургууль өөр дээрээ бүрдүүлж, шийдвэр гаргалтад ашиглах.
6. Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг сайжруулах.

#### IV. Ярилцлагад оролцогчдын нэрс

##### I. Багш нарын нэрс

Тэнхим	Багшийн нэрс	Зэрэг	Гарын үсэг
Эх барихын тэнхим	Т.Эрдэнэтуяа	Багш	
	Б.Туул	Багш	
	Х.Цэцэгсүрэн	Ахлах багш	
	Л.Туяацацрал	Багш	
	С.Сэржняам	Багш	
Насанд хүрэгчдийн сувилахуйн тэнхим	Ч. Энхтуул	Багш	
	С.Дэлгэрмаа	Багш	
	Д.Алтантуул	Багш	
	Ж.Ариунаа	Багш	
НЭМС тэнхим	С.Баттогтох	Ахлах багш	

##### II. Оюутны нэрс

№	Курс	Оюутны нэр
1	I	Ө.Энхзул
2	I	Г.Оюунбилэг
4	II	Дөлгөөн
5	II	Далайцэрэн
6	III	Х.Нуржол
7	III	Ц.Эрдэнэбилэг
8	III	Урангоо
9	III	М.Ренчинханд
10	IV	О.Сарангуа
11	IV	А.Алгирмаа
12	IV	Н.Наурыз
13	IV	Т.Пүрэвсүрэн

##### III. Ажил олгогчдын нэрс

№	Албан байгууллага	Оюутны нэр	Албан тушаал	Мэргэжил
1	Хүрээ АГ	О. Буянхүү	Чанарын албаны менежер	Эх барих-эмэгтэйчүүдийн эмч
2	Өргөө АГ	Г.Насанжаргал	Сургалтын албаны мэргэжилтэн	Эх барих-эмэгтэйчүүдийн эмч
3	Амгалан АГ	Д.Өсөхцэцэг	Сувилахуйн албаны дарга	Сувилагч
4	ЭХЭМҮТ	Д.Мөнхөө	Сувилахуйн албаны арга зүйч	Эх баригч

##### IV. Төгсөгчдийн нэрс

№	Овог нэрс	Төгссөн он	Байгууллага	Албан тушаал
1	Э.Минжүүр	2019	Хүрээ АГ	Эх баригч
2	Б.Сарнай	2019	АШУҮИС-II	Оюутан
3	Л.Одгэрэл	2018	Ажилгүй	-
4	Б.Хонгорзул	2018	Декрет	Эх баригч
5	Г.Баасандулам	2016	Өргөө АГ	Эх баригч
6	Н.Отгончимэг	2015	Өргөө АГ	Эх баригч
7	А.Халиунаа	2019	Хүрээ АГ	Эх баригч
8	Б.Бадамсүрэн	2014	Хүрээ АГ	Эх баригч
9	Н.Алтангэрэл	2018	АШУҮИС-III	Оюутан

**V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал**  
/албан бичгийг оруулах/



**АШУУИС | СУВИЛАХУЙН СУРГУУЛЬ**

Ангальсан Шинжээч: Улаанбаатарын Их Сургууль  
Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 6-р хороо,  
Ард Аюушийн гудамж,  
Улаанбаатар-26 салбар, 188-р шуудангийн хайрцаг,  
И-мэйл: nursing@mnuums.edu.mn, Вeб: nursing.mnuums.edu.mn  
Утас: 70007633, Факс: 976-70007633

2020.01.14 № 14/12  
танвй \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**БОЛОВСРОЛЫН МАГАДЛАН  
ИТГЭМЖЛЭХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
АЖЛЫН АЛБАНД**

АШУУИС-ийн Сувилахуйн сургуулийн бакалавр Эх баригч бэлтгэх сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шинжээч нарын үнэлгээний тайлантай танилцлаа. Шинжээч нарын үнэлгээг зөвшөөрсөн болно.

ЗАХИРАЛ



Н.НАРАНБААТАР

## ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр

Мэргэжлийн зөвлөлийн хуралдаан (огноо) .....  
[Мэргэжлийн зөвлөлийн хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж /Recommendations/**

## ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр

Магадлан итгэмжлэх комиссын хуралдаан (огноо) .....  
[Магадлан итгэмжлэх комиссын хэлэлцүүлгийн дүгнэлт]

Магадлан итгэмжлэх эсэх	Магадлан итгэмжлэл олгох хугацаа

**Зөвлөмж /Recommendations/**